



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/56

Хэрлэн сум

Нэгдсэн золголтын арга хэмжээ
зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хилэнт эх хэмээх” Модон луу жилийн сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн нэгдсэн золголтын арга хэмжээг зохион байгуулахад 4,502,600 (дөрвөн сая таван зуун хоёр мянга зургаан зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйлцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хавсралт

2024.01.31

Зардлын тооцоо

№	ААМ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Идээ засах	1	380000	380000
2	Хүнсний материал	1	3521800	3521800
3	Шатахуун	40	2520	100800
5	Бусад	10	50000	500000
Нийт дүн				4502600